



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 05 сарын 20 өдөр

Дугаар 176

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.2.1, 6.4.3, 6.4.4, 6.5, 6.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Увс-А33А" төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 4 нэрийн, нийт 37,512,836.00 (гучин долоон сая таван зуун арван хоёр мянга найман зуун гучин зургаан) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, "Увс-А33А" төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Ц.Цэдэнбал нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, устгах, сэлбэгээр орлогод авах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Акталж данснаас хассан тээврийн хэрэгслийг улсын бүртгэл болон татвар төлөгчийн бүртгэлээс хасуулж, арга хэмжээний биелэлтийг 2021 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ


ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ



132001380

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газрын 2021 оны 05 дугаар сарын 20-ны
өдрийн 16 дугаар тогтоолын хавсралт



**"Увс-АЗЗА" төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн
хөрөнгөд бүртгэлтэй акталж, данснаас хасах хөрөнгийн
жагсаалт**

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл /төгрөг/
1	Зөөврийн асфальт завод	2008	36,363,636.00
2	УАЗ-чиргүүл	2007	488,400.00
3	Вагон сууц	1987	160,800.00
4	Гэр	2006	500,000.00
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН			37,512,836.00 (гучин долоон сая таван зуун арван хоёр мянга найман зуун гучин зургаан)